

InvesCore FI

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02-р сарын 28-ны өдөр

№ 25/13

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл байгуулах журмын 6.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/09 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зэргэлдээ компани болох “Инвескор Пропери” ХХК-тай Ай Си Тауэр барилгад доорх үнээр “Авто зогсоол түрээслэх, түрээслүүлэх гэрээ” байгуулах саналыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - Түрээслэх зогсоолын тоо: 6 ширхэг зогсоол
 - Нэг зогсоолын сарын түрээс: 500,000 төгрөг
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах, “Авто зогсоол түрээслэх, түрээслүүлэх гэрээ”-нд Компанийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Б.Буд/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



Ч. ХАШЧУЛУУН

Д. ЭНХБАТ

Ч. ӨНӨРЖАРГАЛ

Т. ТЭЛМЭН